

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/47/-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.govisumber@audit.gov.mn</p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Ц.Батсайхан Утас: 70543179 Цахим хаяг: batsaikhants@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК Захирал: Ш.Ичинхорлоо Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.ЦЭРЭННЯМ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.САРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	38,929,905.68	39,783,940.68
33	АВЛАГА	15,043,492.00	14,938,200.00
33500	Бусад авлага	15,043,492.00	14,938,200.00
33510	Байгууллагаас авах авлага	105,292.00	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	14,938,200.00	14,938,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	23,886,413.68	24,845,740.68
35100	Түүхий эд материал	13,563,636.16	13,563,636.16
35110	Тусгай зориулалттай материал	13,563,636.16	13,563,636.16
35400	Хангамжийн материал	10,322,777.52	11,282,104.52
35410	Бичиг хэргийн материал	105,000.00	210,000.00
35420	Аж ахуйн материал	4,132,500.00	5,277,500.00
35460	Хүнсний материал	1,078,717.52	788,044.52
35470	Бусад хангамжийн материал	5,006,560.00	5,006,560.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,603,979,797.75	1,610,531,948.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,603,979,797.75	1,610,531,948.78
39200	Биет хөрөнгө	1,602,039,070.05	1,608,934,323.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,583,428,040.16	1,583,428,040.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	-52,780,934.64	-79,171,401.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	11,000,000.00	3,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-11,000,000.00	-825,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	115,977,718.86	79,761,445.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-105,928,844.95	-35,060,936.11
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	99,672,905.36	75,089,261.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-58,303,769.10	-38,960,765.34
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,052,676.78	1,574,807.56
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,283,244.22	0.00
39217	Ном	18,204,521.80	19,798,872.10
39300	Биет бус хөрөнгө	1,940,727.70	1,597,625.00
39301	Програм хангамж	1,082,000.00	1,082,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-581,272.30	-924,375.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,440,000.00	1,440,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,642,909,703.43	1,650,315,889.46
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,642,909,703.43	1,650,315,889.46
51	Засгийн газрын хувь оролцоо	1,642,909,703.43	1,650,315,889.46
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	447,993,962.42	447,993,962.42
51200	Хуримтлагдсан үр дүн	-73,001,937.63	-65,595,751.60
51210	Өмнөх үеийн үр дүн	-58,596,078.59	-73,606,763.79
51220	Тайлант үеийн үр дүн	-14,405,859.04	8,011,012.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,267,917,678.64	1,267,917,678.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,642,909,703.43	1,650,315,889.46

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	524,812,068.83	617,136,350.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,344,068.83	37,160,950.22
120	Нийтлэг татварын бус орлого	23,344,068.83	37,160,950.22
120003	Торгуулийн орлого	144,690.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	17,649,899.67	36,040,950.22
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,549,479.16	1,120,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	501,468,000.00	579,975,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	362,485,100.00	406,487,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	362,485,100.00	406,487,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	497,400.00	4,702,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	497,400.00	4,702,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	138,485,500.00	168,786,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	138,485,500.00	168,786,000.00
132002	Хаагдсан данс	0.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	539,217,927.87	609,125,338.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	539,217,927.87	609,125,338.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	511,811,474.87	592,414,345.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,548,291.00	324,297,111.00
210101	Үндсэн цалин	276,548,291.00	207,880,931.00
210102	Нэмэгдэл	0.00	89,148,951.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	0.00	27,267,229.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,986,447.00	43,050,141.98
210201	Тэтгэврийн даатгал	24,509,893.00	31,077,094.19
210202	Тэтгэмжийн даатгал	2,883,521.00	3,426,355.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,246,336.00	2,875,074.42
210204	Ажилгүйдлийн даатгал	476,930.00	524,999.46
210205	Эрүүл мэндийн даатгал	4,869,767.00	5,146,618.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,685,872.00	151,434,498.68
210301	Гэрэл, цахилгаан	1,271,254.00	1,702,823.02
210302	Түлш, халаалт	127,554,015.00	141,518,608.00
210303	Цэвэр, бохир ус	3,860,603.00	8,213,067.66
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,564,200.00	2,562,300.00

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	1,224,300.00	1,220,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,600,000.00	601,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	400,000.00	75,000.00
210404	Ном, хэвлэл	561,400.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	6,598,500.00	485,000.00
2105	Нормативт зардал	13,595,049.50	6,144,121.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,000.00	80,200.00
210502	Хоол, хүнс	13,511,049.50	6,063,921.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	17,237,000.00
210604	Урсгал засвар	0.00	17,237,000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	70,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	70,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,347,300.00	1,335,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	237,300.00	115,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	890,000.00	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,084,315.37	46,284,173.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	482,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,394,200.00	248,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,690,115.37	45,553,973.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,406,453.00	16,710,992.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,619,000.00	14,181,475.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,923,000.00	12,354,257.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	696,000.00	1,827,218.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,444,400.00	219,793.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,444,400.00	219,793.32
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,343,053.00	2,309,724.02
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,343,053.00	2,309,724.02
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-14,405,859.04	8,011,012.19
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-14,405,859.04	8,011,012.19

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	447,993,962.42	1,267,917,678.64	-73,001,937.63	1,642,909,703.43
2	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	447,993,962.42	1,267,917,678.64	-73,001,937.63	1,642,909,703.43
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-604,826.16	-604,826.16
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	447,993,962.42	1,267,917,678.64	-73,606,763.79	1,642,304,877.27
5	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	8,011,012.19	8,011,012.19
6	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	447,993,962.42	1,267,917,678.64	-65,595,751.60	1,650,315,889.46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	501,468,000.00	579,975,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	501,468,000.00	579,975,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	362,485,100.00	406,487,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	362,485,100.00	406,487,400.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	497,400.00	4,702,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	497,400.00	4,702,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	138,485,500.00	168,786,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	138,485,500.00	168,786,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	501,468,000.00	563,625,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	501,468,000.00	563,625,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	473,403,947.00	546,552,319.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,831,029.00	325,048,752.98
210101	Үндсэн цалин	182,588,220.00	235,513,169.98
210102	Нэмэгдэл	71,734,090.00	62,831,453.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	27,508,719.00	26,704,130.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,986,468.00	42,618,500.00
210201	Тэтгэврийн даатгал	22,539,362.00	42,618,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,359,276.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,687,461.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	671,816.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,728,553.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,804,600.00	151,329,206.68
210301	Гэрэл, цахилгаан	1,271,254.00	1,702,823.02
210302	Түлш, халаалт	127,567,451.00	141,518,608.00
210303	Цэвэр, бохир ус	3,965,895.00	8,107,775.66
2104	Хангамж, бараа материалын зардал	5,745,000.00	2,490,500.00
210401	Бичиг хэрэг	500,000.00	1,223,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,600,000.00	601,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	400,000.00	75,000.00
210404	Ном, хэвлэл	64,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,001,000.00	410,000.00
2105	Нормативт зардал	11,802,150.00	5,591,360.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,000.00	80,200.00
210502	Хоол, хүнс	11,518,150.00	5,411,160.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	100,000.00

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,236,500.00	17,237,000.00
210604	Урсгал засвар	2,236,500.00	17,237,000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	70,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	70,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,844,700.00	1,335,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	734,700.00	115,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	890,000.00	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,153,500.00	832,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	482,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,153,500.00	350,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,064,053.00	17,073,080.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,276,600.00	14,543,563.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,580,600.00	12,716,345.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	696,000.00	1,827,218.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,444,400.00	219,793.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,444,400.00	219,793.32
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,343,053.00	2,309,724.02
213502	Хаагдсан данс	0.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,343,053.00	2,309,724.02
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	16,350,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	16,350,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	16,350,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	16,350,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	16,350,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-16,350,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	575,273,400.00	572,743,882.66	2,529,517.34	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	575,273,400.00	572,743,882.66	2,529,517.34	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	559,530,300.00	558,200,319.66	1,329,980.34	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	325,055,000.00	325,048,752.98	6,247.02	100.
210101	Үндсэн цалин	276,140,200.00	235,513,169.98	40,627,030.02	85.2

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	28,208,600.00	62,831,453.00	-34,622,853.00	222.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	342,000.00	0.00	342,000.00	0.00
210104	Урамшуулал	20,364,200.00	26,704,130.00	-6,339,930.00	131.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,618,500.00	42,618,500.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	42,618,500.00	42,618,500.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	151,549,000.00	151,329,206.68	219,793.32	99.8
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	1,702,823.02	1,297,176.98	56.7
210302	Түлш, халаалт	142,549,000.00	141,518,608.00	1,030,392.00	99.2
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	8,107,775.66	-2,107,775.66	135.1
2104	Хангамж, бараа материалын зардал	1,620,500.00	1,620,500.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	115,200.00	541,100.00	-656,300.00	469.7
210402	Тээвэр, шатахуун	316,400.00	494,400.00	-810,800.00	156.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	107,700.00	75,000.00	-182,700.00	69.6
210404	Ном, хэвлэл	42,000.00	0.00	-42,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,100.00	180,000.00	-420,100.00	74.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	799,100.00	330,000.00	-1,129,100.00	41.3
2105	Нормативт зардал	6,690,100.00	5,591,360.00	1,098,740.00	83.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,200.00	80,200.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	6,509,900.00	5,411,160.00	1,098,740.00	83.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,237,000.00	30,237,000.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	13,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	17,237,000.00	17,237,000.00	-34,474,000.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	70,800.00	70,000.00	800.00	98.8
210702	Дотоод албан томилолт	70,800.00	70,000.00	800.00	98.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,339,400.00	1,335,000.00	4,400.00	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	119,400.00	115,000.00	4,400.00	96.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	220,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	350,000.00	350,000.00	0.00	100.0

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	350,000.00	350,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,743,100.00	14,543,563.00	1,199,537.00	92.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,743,100.00	14,543,563.00	1,199,537.00	92.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,870,300.00	12,716,345.00	1,153,955.00	91.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,872,800.00	1,827,218.00	45,582.00	97.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	575,273,400.00	572,743,882.66	2,529,517.34	99.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	406,487,400.00	404,177,675.98	2,309,724.02	99.4
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	406,487,400.00	404,177,675.98	2,309,724.02	99.4
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	168,786,000.00	168,566,206.68	219,793.32	99.8
320001	Орон нутгийн төсвөөс	168,786,000.00	168,566,206.68	219,793.32	99.8
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	187.00	206.00	-19.00	110.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	29.00	0.00	111.5
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	9.00	12.00	0.00	133.3

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,702,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,352,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,352,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	870,000.00
210401	Бичиг хэрэг	682,500.00
210402	Тээвэр, шатахуун	107,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	80,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	482,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,350,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,350,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,350,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,702,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,702,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,702,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говьсүмбэр аймгийн Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн ахлах аудитор Ц.Энхтуяа, захирал Ш.Ичинхорлоо, нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтыг менежер И.Туяа, дараагийн шатны чанарын хяналтыг Төрийн аудитын газрын менежер Г.Наранбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар хэрэгжүүлэв.

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 02 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар хүртээмжийг сайжруулна” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Танхимын сургалт удаан хугацаагаар зогссоны улмаас хүүхдийн дунд үүсэж болзошгүй түгшүүр, хөгжлийн ялгаатай байдал, сурлагаар хоцрох, сургууль завсардах зэрэг эрсдэлээс сэргийлэх хариу арга хэмжээ авч, тэгш бус байдлыг бууруулах ажлыг хэрэгжүүлж, үр дүнг тооцох;
- Гэнэтийн буюу давтагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, сургалтын танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл оролцоог дэмжин тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулах;
- Багш ээлжит хичээлийн бэлтгэлийг сургалтын хэлбэрээс үл хамааран чанартай бэлтгэж, үр дүнтэй хэрэгжүүлэх;
- Багшид үзүүлэх мэргэжил арга зүйн дэмжлэг, туслалцааг суралцагч асуудалд бүтээлчээр хандах, учир шалтгааныг эрэлхийлэх, дүн шинжилгээ хийх, шинэ санаа шийдэл гаргах, асуудал шийдвэрлэх гэх зэрэг суралцах идвэхтэй үйлийг дэмжсэн арга зүйг хөгжүүлэхэд чиглүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” хүчингүй болж, 2021 оны 190 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан тушаал “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” журам тайланд онд шинээр мөрдөгдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан зардлын төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 575,273.4 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 11,505.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 9,204.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 244,262.0 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	15,043.5	14,938.2	-105.3
Бараа материал	23,886.4	24,845.7	959.3
Үндсэн хөрөнгө	1,603,979.8	1,610,531.9	6,552.1
Нийт хөрөнгө	1,642,909.7	1,650,315.9	7,406.2
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Хуримтлагдсан үр дүн	(73,001.9)	(91,692.3)	(18,690.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,642,909.7	1,650,315.9	(7,406.2)

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 105.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг бууруулсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 24,845.7 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны дүн 6,552.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 16,350.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 9,944.3 мянган төгрөгийн хөрөнгийг БШУЯ, аймгийн БСГ-аас үнэ төлбөр хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотой байна;

Тайлант оны хуримтлагдсан үр дүн 18,690.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласантай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Үйл ажиллагааны нийт орлогын дүн	524,812.1	591,039.7	66,227.6
Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт	362,485.1	406,487.4	44,002.3
Дээд шатны төсөв захирагчаас	497.4	4,702.0	4,204.6
Орон нутгийн төсвөөс санхүүжих	138,485.5	168,786.0	30,300.5
Торгуулийн орлого	144.7	0.0	(144.7)
Үнэ төлбөргүй орлого	23,199.4	11,064.3	(12,135.1)
Үйл ажиллагааны нийт зардлын дүн	539,218.0	609,125.3	69,907.3
Бараа үйлчилгээний зардал	511,314.1	592,414.3	81,100.2
Урсгал шилжүүлгийн зардал	27,903.9	16,711.0	(11,192.9)

Баянтал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн тусгай шилжүүлгийн орлого өмнөх оноос 44,002.3 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжих орлого 30,300.5 мянга, дээд шатны төсөв захирагчаас олгосон санхүүжилт 4,204.6 мянга, нийт 78,507.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Тайлант онд 609,125.3 мянган төгрөгийн зарцуулалттай ажилласан нь өмнөх оноос 69,907.3 мянган төгрөгөөр буюу 13.0 хувиар нэмэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны тусгай шилжүүлгийн төсвийн хуваарийг 6 удаа, орон нутгийн төсвийн хуваарийг 3 удаа аймгийн ИТХ -аас тодотгон баталсан байна.

Нийт зарлага, цэвэр зээлийн дүн болон зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг анх 1 дүгээр сард 327,039.4 мянган төгрөгөөр баталсан бол 12 дугаар сард 575,423.3 мянган төгрөгөөр баталж, анхны баталсан дүнгээс 248,3836.9 мянган төгрөг буюу 75.9 хувиар нэмэгдүүлэн баталжээ.

Тайлант онд тус сургууль Ковид-19 цар тахлын үед боловсролын салбарын тэгш хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор “Хөгжсөн багш, хичээнгүй сурагч” төслийн хүрээнд Интерактив дасгал даалгавар болон цахимаар сурагчдын сонирхолд нийцсэн чанартай хичээлүүдийг бэлтгэн алслагдмал малчдын хүүхдүүдэд хүрч ажиллах хичээлийн сан бүрдүүлэх зорилгоор 4,300.0 мянган төгрөгийг төлөвлөж, зарцуулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 575,273.4 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай шилжүүлгийн санхүүжилт 406,487.4, орон нутгийн төсвийн санхүүжилт 168,785.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, 572,676.4 мянган төгрөгийг зарцуулж, 99.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулалт нь бараа ажил үйлчилгээний зардал /цалин, НДШ/-ын хэмнэлттэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас тайлант онд 4,702.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосноос хангамж, бараа материалын зардалд 870.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 482.0 мянга, биет бус хөрөнгө худалдан авахад 3,350.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар “Хөгжсөн багш, хичээнгүй сурагч” төслийг хэрэгжүүлэн сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгах чиглэлээр Интерактив дасгал даалгавар болон цахимаар сурагчдын сонирхолд нийцсэн чанартай хичээлүүдийг бэлтгэн алслагдмал малчдын хүүхдүүдэд хүрч ажиллах хичээлийн сан бүрдүүлэх төслийг 4,300.0 мянган төгрөгөөр хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 4 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 100.0 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар, хүртээмжийг сайжруулах” 8 зорилтын хүрээнд 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл нь 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 149 мэдээллийг ил тод байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцтэй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Татварын ерөнхий хуулийн хэрэгжилт

Тайлант онд хийсэн 205,746.5 мянган төгрөгийн худалдан авалт, ажил үйлчилгээний төлбөрийн баримтыг И баримт цахим төлбөрийн баримтын системд шивүүлэхдээ 57,999.0 мянган төгрөгийн баримтыг шивүүлж, баталгаажуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэнтэй нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 2 зөвлөмжийн хэрэгжилтийг хянахад төлбөрийн акт, албан шаардлага болон 1 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувь байна.

И баримт цахим төлбөрийн баримт системийн хэрэгжилтийн талаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүйгээс тайлант онд давтагдсан байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	320.0	1	320.0			
Албан шаардлага	2	1,471.7	1	1,471.7	-	-	100.0
Зөвлөмж	2	4,052.7	1	4,052.7	1		70.0
Нийт дүн	3	5,844.4	2	5,844.4	1		-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 110,191.2 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 52,193.2 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 57,998.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой шинээр үнэлсэн үндсэн хөрөнгийн 26,096.6 мянган төгрөгийг дахин үнэлгээний нэмэгдэл дансанд буруу бүртгэж тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй орлогыг 26,096.6 мянган төгрөгөөр дутуу бүртгэж тайлагнасныг тус тус залруулсан

4.2 Төлбөрийн акт байхгүй

4.3 Албан шаардлага

4.3.1 Тайлант хугацаанд хийсэн зарим худалдан авалтын 57,998.0 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг цахим төлбөрийн баримтыг системд шивүүлээгүй, Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д *“Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”* гэсэн заалтын дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.4 Зөвлөмж байхгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитаар											
1	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой шинээр үнэлсэн үндсэн хөрөнгийн 26,096.6 мянган төгрөгийг дахин	1	26096,0	1	26096.0						
2	Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй орлогыг 26,096.6 мянган төгрөгөөр дутуу бүртгэж тайлагнасан	1	26096,0	1	26096.0						
Санхүүгийн тайлангийн аудитаар хийсэн нийцлийн аудит											
1	Е баримт цахим төлбөрийн баримтын системд худалдан авалт, ажил үйлчилгээний 57,998.0 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг шивүүлж	1	57,998.0					1	57,998.0		
	Нийт дүн	1	110,191.2	1	52,193.2			1	57,998.0		

